



**“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Дархан-Уул аймаг

2023 он

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн

нөөцийн удирдлагын газрын дарга _____

(Г.Энхмөнх)

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК

Гүйцэтгэх захирал _____



М.Жаргалсайхан

“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК
Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р багийн нутагт
орших цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах үйлдвэр
/Аж ахуй нэгжийн РД:2688549/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн _____

П.Шинэцэцэг

Боловсруулсан:

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК

Хяналтын хэлтсийн

Байгаль орчны хяналтын инженер _____

Н.Батсайхан

2023 он

1.Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	“Дулааны цахилгаан станц” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК
Төслийн дугаар:	2018/М-69
Улсын бүртгэлийн дугаар:	9012001010
Регистрийн дугаар:	2688549
Хаяг байршил:	Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, Үйлдвэрийн дүүрэг, Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн байр
Утас:	7037-3022, 7037-3021
Төслийн байршил:	Дархан-Уул аймаг, Дархан сумын нутаг дэвсгэрт. Дархан хотын зүүн урд хэсэг болох Үйлдвэрийн дүүрэгт гүний худгийн зориулалтаар 14,25га, үнсэн сан 93,71га, эрчим хүчний зориулалттай 25,64га буюу нийт 133,6га талбайг эзлэн оршдог. / Хойд өргөргийн 49°26', зүүн уртрагийн 105°57'./

Дарханы дулааны цахилгаан станцыг анх Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 05-р сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоолоор Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт барьж байгуулах шийдвэр гарч 1963 оны 11-р сарын 04-нд суурийг тавих ёслол болж 1965 оны 10-р сарын 02-нд анхны үндсэн тоноглолуудыг ашиглалтад оруулж цахилгаан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд түгээж эхэлсэн түүхтэй эрчим хүчний салбарын ууган үйлдвэрүүдийн нэг юм. Төвийн Эрчим Хүчний системийн даргын 1992 оны 12 дугаар 20-ны өдрийн 149 дүгээр тушаалаар Төрийн Өмчийн Улсын Үйлдвэрийн Газар, 2001 оны 7-р сарын 09-ний өдрийн Засгийн Газрын 164-р тогтоолоор “ДДЦС” ТӨХК болгон зохион байгуулагдсан.

Тус станц нь анх ЗХУ-д үйлдвэрлэгдсэн тус бүр нь цагт 39 ата, 435 градус температуртай 75 т/ц уур боловсруулах хүчин чадалтай БКЗ-75-39ФБ маркийн 6ш зуух, тус бүр нь цагт 12 МВт/ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай ПТ-12/35-10 маркийн 4ш турбингенераторыг суурилуулан цагт 48 МВт буюу жилд 302,2 сая.кВтцаг ЦЭХ, 903,6 мянган Гкалл дулааны эрчим хүч боловсруулах хүчин чадалтай байгуулагдсан.

Дархан-Уул аймгийн дулааны хэрэглээ өссөнтэй холбогдуулан 1985-1987 онуудад ОХУ-н БКЗ-75-39Ф маркийн цагт 75 тн уур үйлдвэрлэх хүчин чадал бүхий 3-н зуух, РОУ-40/11 маркийн бууруулан хөргөх төхөөрөмж 3ш, РРОУ-40/3,0 маркийн бууруулан хөргөх төхөөрөмж 1ш, дулаанжуулалтын тоноглол болох сүлжээний зуны горимд ашиглах хэрэгцээний ус халаагч ПСВ-200-7-15 маркийн ус халаагч 1ш, ПСВ-315-3-23 маркийн 1ш үндсэн бойлер, ПСВ-315-14-23 маркийн 1ш туслах бойлер, СН-5, АБН№1,2, АБНН№1,2,3, ХУХНН№1,2,3 насосууд, усыг хийгүйжүүлэх төхөөрөмж болох ВД№1,2 зэргийг шинээр нэмж суурилуулж ашиглалтад оруулсан. Мөн тунгаасан усны эргэлтийн шугам хоолой, насос станц, үнс баригч 18ш скруббер шинээр байгуулан, 120 метр өндөр янданг ашиглалтад оруулсан.

Мөн станцын найдвартай ажиллагааг дээшлүүлэх, ажиллах хугацааг уртасгах зорилгоор 1993-1995 онуудад ХБНГУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 15,6 сая дойч маркийн хөрөнгө оруулалт хийж ДАРХАН-1 ба ДАРХАН-2 төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд 4 зуухны бүрэн хэмжээний их засварыг хийж халах гадаргуу, өрлөгийг бүрэн солих, 1 турбинд горимын өөрчлөлт хийж сүүлийн хэсэг шинэчлэн солих, хурц уурын шугам хоолой, коллекторыг хаалт арматурын хамт бүрэн солих, дулаанжуулалтын тоног төхөөрөмж нь хуучирч элэгдсэн учир сүлжээний 2,3-р секцийн бойлеруудын хүчин чадлыг нэмэгдүүлж шинэчлэн ПСВ-500-3-23 маркийн үндсэн, ПСВ-500-14-23 маркийн туслах бойлеруудаар солих, шугамын өргөтгөл хийх, 1 зуухыг компьютерын хяналт удирдлагын системд шилжүүлэх болон

дулаанжуулалтын тоноглолын хэмжүүр, хэмжих хэрэгслийн шинэчлэлт зэрэг томоохон ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

2011-2019 онд “Эрчим хүчний үр ашиг 1” хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-н хөнгөлөлттэй урт хугацааны зээлийн хөрөнгөөр компьютерын хяналт удирдлагын системтэй ПТ-35/39-3,4/1,0 маркийн 35 МВт-ын шинэ турбингенераторыг туслах тоноглолын хамт суурилуулах төслийг амжилттай хэрэгжүүлэн суурилагдсан хүчин чадлаа 48-83 МВт болгон нэмэгдүүлснээр цагт 83 МВт буюу жилд 446,9 сая.кВтцаг ЦЭХ, 906 мянган Гкалл ДЭХ үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай болсон. Үндсэн ба туслах тоноглолууд нь сүүлийн үеийн хянах хэмжүүр, автоматикийн хэрэгслээр бүрэн тоноглогдсон. Мөн Тр-1,2, Градирн №1-ийн шинэчлэлийн ажлыг амжилттай хэрэгжүүлж дуусган ашиглаж байна.

Жилд дунджаар 500 мянган тн нүүрсийг Шарын гол болон Багануурын уурхайгаас авч технологийн хэрэгцээндээ ашигладаг. /2006 оноос Шарын голын уурхай нүүрсээр бүрэн хангаж чадахгүй болсон тул Багануур болон бусад уурхайн нүүрс авч ашиглаж байна. Үүнтэй холбоотойгоор 2007 оноос 2 зуухыг нам температурын буцламгай үет шаталтын технологид, 1 зуухыг шууд үлээлгийн технологит шилжүүлээд байна./

Мөн ажилтны ажиллах нөхцөлийг дээшлүүлэх, үндсэн тоноглолын хяналтыг сайжруулах зорилгоор 2008-2020 онуудад БКЗ-75-39Ф маркийн нийт 9ш зуух, ПТ-12/35-10 маркийн 1ш турбингенераторыг КХУС /компьютерын хяналт удирдлагын систем/-д шилжүүлээд ажиллаж байна.

Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэх чадвар бүхий мэргэжилтэй ажилтан, инженер техникийн ажилтнаар бүрэн хангагдсан. Ажилтны тоо 484

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны аудит, газрын төлөв байдал хянан баталгааны ажлыг хуулийн дагуу хийлгэж өгөгдсөн заавар зөвлөмжийн дагуу эрсдэлийг бууруулан ажилладаг.

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.

Дархан хотын зүүн урд хэсэг болох Үйлдвэрийн дүүрэгт гүний худгийн зориулалтаар 14,25га, үнсэн сан 93,71га, эрчим хүчний зориулалттай 25,64га буюу нийт 133,6га талбайг эзлэн оршдог.

“Дархан Дулааны Цахилгаан Станц” Төрийн өмчит хувьцаат компани нь дулаан, цахилгааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэдэг компани юм. Дархан- Сэлэнгийн бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр, Монголын хоёрдогч том хот болох Дарханыг дулааны эрчим хүчээр хангадаг цор ганц цогцолбор юм.

“ДДЦС” ТӨХК нь Төвийн бүсийн Эрчим хүчний системийн бүрэлдэхүүнд багтан үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ 6, 35, 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамуудаар хэрэглэгчдэд түгээдэг бөгөөд 110 кв-ын шугамаар Дарханы 220 кВ-ын дэд станц, Сүхбаатар, Дархан, Ерөө, Шарын гол, 35 кВ-ын шугамаар Энх тал, Орхон, Хонгор сум, Дарханы үйлдвэр аж ахуйн газруудтай 6 кВ-ын шугамаар холбогдож Дархан-Сэлэнгийн район, Дархан-Уул аймгийг цахилгаан эрчим хүчээр хангадаг. Тус станц нь Үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчээ “ДДС” ТӨХК-ийн дулаан дамжуулах шугам тоноглолоор дамжуулан Дархан хотын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг хэрэгцээний халуун ус, дулаацуулгаар бүрэн хангаж байгаагийн зэрэгцээгээр үйлдвэр, ААН байгууллагуудыг технологийн хэрэгцээний уураар хангадаг.

Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд, Сэлэнгэ аймгийн төв хэсэгт, Хэнтийн нурууны салбар уулсын хоорондох намхан гүвээ толгод, Хараа голын хөндийд далайн түвшнээс дээш 705 м өндөрт, уртрагийн 105° 56', өргөргийн 49° 29' байршдаг.

Дархан-Уул аймаг нь Монгол орны төвийн бүсэд аж үйлдвэр, соёл, боловсрол, шинжлэх ухааны хоёрдогч том төв болсон болж хөгжсөн. Монгол Улсын Их хурлын 1994 оны 32 дугаар

тогтоолоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан-Уул аймаг болж, засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 24 багтай 90,7 мянган хүн амтай үүнээс 74,9 мянган хүн Дархан суманд амьдардаг. Нийт хүн амын 64,5 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг.

Дархан-Уул аймаг нь 327,8 мянган га газар нутагтай, нийт газар нутгийн 70,7 хувь буюу 231,7 мянган га талбайг ХАА, 22,2 хувь нь тусгай хэрэгцээний эдэлбэр бусад нь ус, ойн сангийн газар эзэлдэг.


Дархан-Уул аймгийн Дархан сум нь газар зүйн байршлын хувьд 9804 га нутаг дэвсгэртэй. Далайн түвшнээс 705 м өндөрт өргөгдсөн. Орхон Сэлэнгийн сав газрын бүсэд Хараа голын дагуу байрладаг. Хангай хээрийн бүсэд орших бөгөөд нарс, хуш, улиас, гацуур, хар мод бүхий ойтой. Цаг уурын байдал ид халууны үе буюу 7-р сард 45 хэм хүрч халдаг. Өвөлдөө 43,7 хэм хүртэл хүйтэрдэг. Зүүн ба урд талаараа Дархан-Уул аймгийн Хонгор, хойд талаараа Орхон сум, баруун талаараа Сэлэнгэ аймгийн Сайхан сумтай тус тус хиллэдэг.

Улаанбаатар хотоос 220 км

Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумаас 100 км

Хилийн боомт Алтанбулаг сумаас 130 км

Орхон аймаг Баян-Өндөр сумаас 180 км зайд оршдог.



3. Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон машин механизмын яндангаас гарч буй утаа, нүүрс хадгалах, хамгаалах, ашиглалтын үед тоос, нефтийн бүтээгдэхүүний ашиглалтын үед хөрсний бохирдол үүсэж болзошгүй сөрөг нөлөөтэй/

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх, байгаль орчноо хайрлан хамгаалахад илүү анхаарч байгаль орчны багц хууль, дүрэм, журамд нийлүүлэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх зорилттой.

“ДДЦС” ТӨХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2023 ОН /

5. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж хэмжээ	Тоо	Нэгжийн зардал (тегрөг)	Нийт зардал (тегрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө									
1	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар шорооны ажлын үед үүсэх агаарын тоосжилт, үйлдвэрийн болон машин механизмдын яндангаас гарч буй хорт хий зэрэг нь тухайн орчинд агаарын бохирдол үүсгэхээс гадна оршин суугчдын эрүүл мэнд болон амьтан ургамал мөн усан орчинд нөлөөлж болзошгүй юм.	Автомашин механизм, тээврийн хэрэгслийн угааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг тогтмол хийж, засвар үйлчилгээг хийх	Нийт авто тээврийн хэрэгсэл				Дотоод төлөвлөлтөд	Тогтмол. Жилд 1 удаа улсын үзлэг орно.	БОНХАЖ сайдын 2015 оны А-301 тоот тушаал Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 Бензин хөдөлгүүрт MNS5013:2013 Дизель хөдөлгүүрт MNS5013:2003 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
2		Ажлын байрны тоосжилтыг бууруулах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах	Станц				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
3		Үнсэн санг салхины хурд ихтэй, хуурай үед чийгшүүлэх	ҮНСЭН сангийн талбай				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	
4		Ажиллагсдын тусгай зориулалтын нормын хувцас хэрэгслээр хангах, /хошуувч, амны макс, чихэвч гэх мэт/ хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	Ажиллагсад				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
5		Зуухнуудын түлшний шаталтын горимыг нарийн барьж дутуу шалтарт гаргахгүй байх арга хэмжээ авах	Зуухан цех				Дотоод төлөвлөлтөд	Тогтмол	
6		Зуух тус бүрээс гарах болон яндангаар хаягдах утааны хийн шинжилгээг хийж, бохирдуулах бодисуудын гаралтыг тодорхойлж, стандарттай харьцуулан дүгнэж байх	Зуухан цех				Дотоод төлөвлөлтөд	Сар бүр	
7		Зуухны засварын өмнө ба дараа горимын туршилт хийж, үзүүлэлтүүдийг харьцуулан дүгнэлт гаргах	Зуухан цех				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1		2	3	4	5	6	7	8	9
8		Түлш нийлүүлэх уурхайнуудтай гэрээ хийхдээ нүүрсний чанарын үзүүлэлтүүдийг (үнслэг, чийглэг, хүхэр агуулалт илчлэг гэх мэт) тодорхой зааж, лабораторид тодорхойлон тохирсон үнэлгээгээр хяналт тавьж ажиллах	Хими цех				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	
9		Агаарын бохирдлыг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулах	Станцын орчинд				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	
Хөрс, ургамлан бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө									
10	<p>Өргөтгөл шинэчлэлийн ажил, төсөл хэрэгжих хугацаанд болзошгүй газар шорооны ажлын үед хөрс ургамлан нөмрөг талхлагдах элэгдэл, эвдрэхийн эерэгцээ тоос, нефтийн бүтээгдэхүүн болон барилгын ажлын хог хаягдлаар бохирдож болзошгүй.</p>	Эзэмшлийн газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх, талхлагдсан хөрсийг ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэх.	Бүх нэгж хэсэг				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	<p>Хог хаягдлын тухай хууль Газрыг тухай хууль Газар ашиглалтын тухай хууль MNS5916:2008 MNS5918:2008 MNS5850:2008 Энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам (БОНХАЖЯ, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 тушаал)</p>
11		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх, талаар жолооч нарт сургалт явуулах.	ХҮХ, Жолооч, ажилчдад				Дотоод төлөвлөлтөд	Жилд	
12		Нүүрс орчинд тархахаас сэргийлж талбайн эмх цэгцгийг сайжруулах	Түлш дамжуулах цех				Дотоод төлөвлөлтөд	тогтмол	
13		Мазут буулгах суваг, мазут, дизель түлшний шугам хоолойд үзлэг хийж алдагдлаас сэргийлэх арга хэмжээ авч байх	Зуухан цех				Дотоод төлөвлөлтөд	тогтмол	
14		Химийн хортой аюултай бодисын ашиглалт болон хадгалалт, хамгаалалтад хяналт тавих.	Хими цех хяналтын хэлтэс				Дотоод төлөвлөлтөд	тогтмол	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө									
15		Усны чанарыг тогтмол хянаж байх, худгуудын үйл ажиллагааг (бөглөрөлт зэврэлтийг) хянаж байх.	Хими цех, Механик бэлтгэл цех				Дотоод төлөвлөлтөд	Тогтмол	
16		Ажилчдын унд ахуйн усанд шинжилгээ хийлгэж байх	Хими цех				Дотоод төлөвлөлтөд	Тогтмол	
17		Үнсэн сангийн далангийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж сэтрэхээс сэргийлэх арга хэмжээ авч байх.	Зуухан цех				Дотоод төлөвлөлтөд	Ашиглалтын үед	
18	Гадаргын болон газар доорх ус бохирдсоноор нутгийн оршин суугчдын ундны ус бохирдох, мөн бохирдсон ус хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, ургамал, амьтан малд нөлөөлж болзошгүй.	Шатах, тослох материалын хаягдал, химийн бодисын асгаралт гаргахгүй байх	бүх цех				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль Эрүүл ахуйн тухай хууль MNS0900:2005 MNS3342:1982 MNS4943:2015 MNS3597:1983 MNS4288:1995 3Г-ын 2013 оны 326 дугаар ТОГТООЛЫН ХАВСРАЛТ
19		Ус ашиглалтын тайлан бүртгэлийг холбогдох газруудад тайлагнаж, ус ашиглалтын төлбөрийг тоолуурын заалтаар тооцон тухайн орон нутгийн төсвийн дансанд оруулах	ИА, ХХ, СБХ				Дотоод төлөвлөлтөд	Тухай бүр	
20		Байгалийн нөөц ашиглах зорилгоор суурилуулсан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, баталгаажуулалтыг хугацааг анхааран хяналт тавих	Хими цех				Дотоод төлөвлөлтөд	Тогтмол	

6. Орчны тохижилт, цэцэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (тегрөг)	Нийт зардал (тегрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
1		Хамгаалалтын хашааг тойруулан мод тарих, /Нарс мод/	Гүний худгийн талбайд	ширхэг	40	67000	2,680,000	5, 10 дугаар сард	
2		Ашиглагдаж дууссан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ. Энэ жил хөрс, шороогоор хучих ажил хийнэ.	Ашиглагдаж дууссан үнсэн сангийн талбайд				100,000,000	5, 10 дугаар сард	Газрын тухай хууль, 6-р бүлэг, 65.6-р заалт. 2021.01.14 өдрийн №63, Ерөнхийлөгчийн зарлиг, Мод тарих үндэсний өдөр, MNS 6257:2011 Сөөгийн суулгац, MNS 6255:2011 Улиасны суулгац, MNS 5918:2008
3	Хөрсний эвдрэл, гэмтэл засаж сайжруулах, ургамалжуулах болон хууль эрх зүйн хэрэгжилтийг ханган ажиллах	Навчит мод, бут сөөг тарих.	Тэрбум мод үндэсний хөтөлбөр, мод тарих өдрийн хүрээнд	ширхэг	10000	24000	24,000,000	5-10 дугаар сард	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн шаардлага MNS 6258:2011 Суулгацын нүхийг бэлтгэх суулгах,
4		Хөрс шороог ургамалжуулах, цэцэгжүүлэх	Үйлдвэрийн хашаан дотор	ширхэг	1000	1500	1,500,000	5-6 сард	
5		Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтарч ажиллах	Мод тарих, ургамалжуул ах, ажилд зөвлөгөө авах				Дотоод төлөвлөлтөд	5-10 дугаар сард	
							128,180,000		

7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Тус байгууллагын эзэмшил газрын ойр орчимд тусгай хамгаалалттай газар нутаг болон түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй. Иймээс төслийн үйл ажиллагаа түүх, соёлын өв, дурсгалт зүйлст сөрөг нөлөө үзүүлэхгүй тул төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй.

8. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Байгаль хүнд цаг уурын байдлаас ховор болон нэн ховор туруутан амьтадын тоо толгой цөөрөх сөрөг нөлөөтэй.	2 Байгаль хүнд цаг уурын байдлыг даван гарахад зориулж биотехникийн арга хэмжээ зохион байгуулах	3 Дархан-Уул аймгийн 2-р багийн нутагт	4 кг	5 1000	6 1000	7 1,000,000	8 2-р сард	9 БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11-д биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах
		Нийт					1,000,000		

9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Гал түймэр, газар хөдлөлт, хүний гоц халдварт өвчин, үер, террорист гэх мэт сөрөг нөлөөлөлд өртөх	2 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж орон нутгийн Онцгой байдлын газрын холбогдох албан тушаалтнаар хянуулан, батлуулж, болзошгүй гамшгийн үед хэрэгжүүлэх	3 Байгууллага болон орон нутгийн хэмжээнд	4	5	6	7	8	9 Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичиг
2	Ажиллагсад хөдөлмөрийн чадвар түр алдах, мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөх зэрэг сөрөг нөлөөлөлтэй.	Ажиллагсдын тусгай зориулалтын нормын хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Ажиллагсад				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш /Нормын дагуу/	ХАБЭА-н заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль
3		Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж байх	Ажиллагсад				Дотоод төлөвлөлтөд	Жилдээ	
4		Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад хор тайлах сүү, жүүс олгож байх	Лабораторийн болон бусад				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш /Нормын дагуу/	

10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1		2	3	4	5	6	7	8	9
1		Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Ажиллагсад				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
2		Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Ажиллагсад				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний явцад гарсан хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Турбин цех болон ХҮХ				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
4		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Цехүүд				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
5		НАА ҮГ-тай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллах	Станц				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш /гэрээний дагуу/	
6		Хог хаягдлын бүртгэл, судалгаа, тайлан мэдээлэл гаргах ажлыг тогтмолжуулах мэдээллийн санд оруулж хяналт тавих, олон нийтэд мэдээлж байх	Станц				Дотоод төлөвлөлтөд	Жилийн турш	
7	Ашиглагдахгүй болсон химийн хортой бодисын үлдэгдэл болон сав баглаа боодлын хаягдал нь эрсдэл дагуулах сөрөг нөлөөтэй	Химийн хортой болон аюултай бодисын хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар устгал хийлгэх	Станц	кг	677.5	5974	4,047,371	7 сард	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
8		Химийн хортой болон аюултай бодисын хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар устгал хийлгэх	Станц	кг	183.6	1622	297,744	7 сард	
							4,345,115		

Нийт дүн

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамж тоо	Нэгжийн зардал	Нийт зардал	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын чанар Хийн хэмжилт: SO ₂ , NO ₂ , CO ₂ , тоосонцор, PM ₁₀ , PM _{2.5}	Үнсэн сангийн зүүн урд-1, Нүүрсний талбайн зүүн урд талд талбай дотор-1, гадна-1	4,10-р сард	2	200,000	400,000	SO ₂ , NO ₂ , CO ₂ , тоосонцор, PM ₁₀ , PM _{2.5} Температур шуугианы урс доргион гэрэлтүүлэг чийгшил тоосжилт	MNS 4585-5016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 3384-1982 Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. MNS 4048-1988 тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.
2	Усны хяналт шинжилгээ Үйлдвэрлэлийн технологийн дамжлага бүрд	Дотоод орчинд өөрсдийн баталгаажсан багаж Усны эх үүсвэр бүрд Технологийн дамжлага бүртд /өөрийн итгэмжлэгдсэн лабораторид/	Сар бүр 4,10-р сард	2	150,000	300,000	Мэдрэмжлэгдэхүй чанар, физик үзүүлэлтүүд хүчилтөрөгчийн үзүүлэлтүүд Эрдсийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд шим бохирдлын үзүүлэлтүүд Нян судлалын үзүүлэлтүүд	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж. MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 13.060.50 Усны чанарын стандарт. MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Хөрсний төлөв байдалд, бохирдол:	Усан хангамж /өөрийн итгэмжлэгдсэн лабораторид/ Станцын орчимд мазут, дизелийн түлшний нөөцийн сав орчим	Жилд 1 удаа	2	90,000	180,000	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс%, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн нүүрс ус төрөгчийн нэгдлүүд, кадьюми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель цайр	MNS 3297 : 2019 Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2018 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Цацраг идэвхт бодис. Хүнд металлууд	Үнсэн сангийн салхин доорх талбай, үнсний сан, нүүрс хадгалах ил сарай орчим	Жилд 1 удаа	2	10,000	20,000	Цацраг идэвхт бодис. Хүнд металлууд	МУ-ын ЗГ-ын 2015 оны 286 дугаар тогтоолоор батлагдсан орчны аюултай байдал болон гамшигт үзэгдлийн түвшин 4.1-д заасан тунгийн хэмжилт түвшин
		Нийт зардал				900,000		

12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь												Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он													
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт														БОХИ Н.Батсайхан	Төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэх
2	Орчны тохижилт, цэцэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт	128,180,000													БОХИ Н.Батсайхан	Дүүрсэн үнсэн сангийн хучилт, нөхөн сэргээлт, Тэрбум мод хөтөлбөр, байгууллагын ногоон байгууламжийн үзэмжийн ажил
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	1,000,000													БОХИ Н.Батсайхан	Биотехникийн ажил зохион байгуулах
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт														Хяналтын хэлтсийн дарга Л.Балт	Төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэх
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	4,345,115													БОХИ Н.Батсайхан	Төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэх
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт	900,000													Лабораторийн эрхлэгч Г.Алимаа,	Төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэх
7	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	35,000,000													БОХИ Н.Батсайхан	Ажил үйлчилгээ авах тендер зарлан мэргэжлийн байгууллагаар хийлгэх
8	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сум, багийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах														БОХИ Н.Батсайхан	Хамтран ажиллах, заавар зөвлөмжийг төлөвлөгөөнд тусган ажиллах

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛСАН “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД “ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2023 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 02 сарын 10

№	Хийгдэх ажлын нэрс	Хамрах хүрээ	Хугацаа	Хэрэгжилт
1. “ТЭР БУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023 онд мод тарих ажлыг бүрэн зохион байгуулж хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлт				
1	“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд мод тарих ажлын төлөвлөгөө гарган батлуулах.	Хяналтын хэлтэс БОХИ	02/10-02/20	
2	Дархан-Уул аймгийн Дархан сумын ЗДТГ-тай мод тарих газрын гэрээг сунгах.	ДС ЗДТГ, БОАЖГ, Газрын алба	03/01-04/20	
3	Аймгийн ЗДТГ, БОАЖГ-тай тарих модны тоо мэдээ, мэдээллийг өгч баталгаажуулах.	ДУАЗДТГ, БОАЖГ, ДДЦС ТӨХК	03/05-04/15	
2. Мод тарих ажлыг зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийн бүрдүүлэх				
4	Мод тарих талбайн хамгаалалтын хашааг засаж сайжруулах, нэмэлтээр барих шаардлагатай хашааны тооцоо, судалгаа гаргах.	Хяналтын хэлтэс БОХИ	03/10-4/30	
5	Байгууллагын 2023 оны худалдан авах төлөвлөгөөнд модны суулгац худалдан авах зардлыг суулгах	Хяналтын хэлтэс БОХИ	2022/12/01- 2023/02/20	
3. Мод тарих хөтөлбөрийн хүрээнд хийгдэх худалдан авалт				
6	Модны суулгац худалдан авах бичиг баримтыг бэлтгэх	Хяналтын хэлтэс БОХИ	03/01-04/01	
7	Мод тарихад шаардлагатай нэмэлт материалын тооцоог гаргах	Хяналтын хэлтэс БОХИ	02/10-03/10	

8	Төндөрт шалгарсан байгууллагаас гэрээний дагуу модны суулгац хүлээн авах.	Хяналтын хэлтэс БОХИ	05/05-05/25	
---	---	-------------------------	-------------	--

4. Сургалт, зөвлөгөөн хамрагдах, зохион байгуулах

9	Дархан-Уул аймаг, БОАЖГ-аас зохион байгуулах сургалт, зөвлөгөөнд хамрагдах.	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс БОХИ	03/10-09/30	
10	Алба, хэлтэс, цехүүдээс мод тарих сургалтад хамрагдах ажилчдыг давтан сургалтад хамруулах.	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс БОХИ	04/01-04/30	
11	Нийт ажилтнуудад мод тарих талаар арга зүйн зөвлөмж өгүүлэх.	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс БОХИ	04/01-04/30	

5. Мод тарих бэлтгэл ажил

12	Мод тарих газрын хамгаалалтын хашааг засварлах, нэмэлтээр сунгах шаардлагатай хашааг барих.	"ДДЦС" ТӨХК алба, хэлтэс, цахууд	04/01-05/01	
13	Мод усалгааны шугам татах, усны нөөцлөх сав байршуулах.	ДДЦС ТӨХК Хими цех, МБЦ	04/01-05/01	
14	Хөрсөнд тэжээл өгөх зорилгоор малын бууц, хар шороо, бордоог бэлтгэх.	Хяналтын хэлтэс БОХИ	04/15-04/30	

6. Мод тарих, арчилж ургуулах, хамгаалах

15	Мод тарих талбай, тарих модны хуваарилалт хийх.	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс БОХИ	04/10-04/25	
			09/10-09/20	
16	Байгууллагын нийт ажилтнуудыг хамарсан мод тарих ажлыг зохион байгуулах.	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс БОХИ	05/05-05/30	
			09/25-10/25	
17	Тарьсан модны арчилгаа, усалгааны хуваарь гарган ажиллах.	"ДДЦС" ТӨХК нийт алба, хэлтэс, цехүүд хуваарийн дагуу	06/01-06/30	
			07/01-07/30	
			08/01-08/30	
			09/01-09/30	

18	Тарьсан модонд шимт тэжээл өгөх. /Нэмэлт тэжээл болох бордоог мэргэжилтний зааварчилгааны дагуу цацах /	"ДДЦС" ТӨХК алба, хэлтэс, цехүүд	06.01-07.30	
19	Гүний худгийн машинист нартай мод тарьсан талбайд мал оруулахгүй байх талаар хамтран ажиллах	"ДДЦС" ТӨХК Хяналтын хэлтэс Хими цех	01/1-12/31	

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.ХАШ-ЭРДЭНЭ

ХХ-ИЙН ДАРГА:

Л.БАЛТ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ХХ-ИЙН БОХМ

Н.БАТСАЙХАН